



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 1799

Улаанбаатар хот

Орон нутгийн хөгжлийн сангийн
санал асуулгыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/415 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг иргэд, олон нийтээс авах ажиллагааг цахим хэлбэрээр болон гар утасны аппликейшн ашиглан дүүрэгт 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдрийг дуустал зохион байгуулсугай.

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг авахад шаардагдах төсвийг хавсралтаар баталж, 480,600 (Дөрвөн зуун наян мянга зургаан зуун) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL\2024 он ажил\захирамж

1123200269

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны...сарын...-ны өдрийн дүгээр
захирамжийн хавсралт



1 ДҮГЭЭР ХОРООНД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт
1.	Бичгийн цаас	боодол	3	25,000	75,000
2	Нэгж дата	-	3	50,000	150,000
3	Бал	Боодол	2	5,000	10,000
Нийт					235,000

2 ДУГААР ХОРООНД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт
1.	Шатахуун	л	40	2,390	95,600
2	Нэгж дата	-	3	50,000	150,000
Нийт					245,600